



# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/192/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4-5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7-8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8-9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13-14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14-15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.МӨНХЖАРГАЛ ТАНАА

### **Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>220,572,097.59</u></b>	<b><u>413,912,276.59</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,479,244.00	60,485,355.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,902,837.00	2,639,237.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	57,846,118.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	7,576,407.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	7,576,407.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	143,294,854.59	353,426,921.59
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	143,294,854.59	353,426,921.59
35410	Бичиг хэргийн материал	27,610,760.00	18,162,685.00
35420	Аж ахуйн материал	26,805,700.59	43,962,700.59
35430	Сэлбэг хэрэгсэл	420,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	2,500,190.00	2,215,498.00
35450	Барилгын засварын материал	7,527,894.00	8,011,894.00
35470	Бусад хангамжийн материал	78,430,310.00	281,074,144.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	66,797,999.00	00.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	66,797,999.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>795,716,878.89</u></b>	<b><u>792,593,134.11</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	795,716,878.89	792,593,134.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	574,811,962.16	572,777,967.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,798,543.00	238,792,043.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,248,888.34	-20,715,688.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	327,389,660.00	314,060,165.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-138,748,030.07	-166,075,627.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	303,063,458.96	285,852,540.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-174,599,510.48	-119,513,912.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,159,309.54	44,559,609.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,239,163.32	-19,895,277.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,224,660.00	25,224,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,988,077.13	-9,510,543.13
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	220,904,916.73	219,815,166.73
39301	Программ хангамж	17,620,000.00	17,620,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,479,583.27	-3,569,333.27
39303	Бусад биет бус хөрөнгө	205,764,500.00	205,764,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,016,288,976.48</u></b>	<b><u>1,206,505,410.70</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>56,269,149.00</u></b>	<b><u>30,594,588.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	56,269,149.00	30,594,588.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	56,269,149.00	30,594,588.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	55,734,149.00	30,084,588.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	535,000.00	510,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	535,000.00	510,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>960,019,827.48</u></b>	<b><u>1,175,910,822.70</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	960,019,827.48	1,175,910,822.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	608,065,850.10	608,065,850.10
51101	Өмч: - төрийн	402,301,350.10	402,301,350.10
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	205,764,500.00	205,764,500.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	304,040,186.78	519,931,182.00
51210	Өмнөх үеийн үр дүн	304,040,186.78	304,040,186.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	215,890,995.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,913,790.60	47,913,790.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,016,288,976.48</u></b>	<b><u>1,206,505,410.70</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>Төгрөгөөр</i>			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,371,183,231.00</b>	<b>1,778,903,829.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,155,000.00</b>	<b>63,174,814.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,155,000.00	700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,155,000.00	700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,155,000.00	700,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	00.00	62,474,814.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,370,028,231.00</b>	<b>1,715,729,015.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,875,000.00	64,120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,275,000.00	64,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1334922300.00	1644352800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,334,922,300.00	1,644,352,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	28,230,931.00	7,256,215.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	28,230,931.00	7,256,215.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,443,573,958.07</b>	<b>1,563,012,833.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,443,573,958.07</b>	<b>1,563,012,833.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,382,950,226.07	1,213,612,039.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	700,362,900.00	706,437,005.00
210101	Үндсэн цалин	552,714,740.00	510,954,324.35
210102	Нэмэгдэл	115,007,016.00	170,020,832.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,641,144.00	25,461,848.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,574,000.00	94,241,500.00
210201	Тэтгэврийн даатгал	66,687,200.00	66,183,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,971,700.00	7,158,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,577,400.00	5,573,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,394,300.00	1,393,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,943,400.00	13,933,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,548,600.00	22,671,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,591,700.00	5,018,377.00
210302	Түлш, халаалт	16,960,000.00	16,036,694.00
210303	Цэвэр, бохир ус	996,900.00	1,616,129.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	144,512,621.00	32,686,037.00
210401	Бичиг хэрэг	4,973,187.00	14,757,975.00
210402	Тээвэр, шатахуун	14,161,700.00	9,441,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,800.00	575,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,027,208.00	7,911,412.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	120,574,726.00	00.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	7,196,484.00	1,656,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,196,484.00	1,656,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,592,455.00	2,398,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,833,049.00	00.00
210604	Урсгал засвар	2,759,406.00	2,398,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	553,400.00	1,369,300.00
210702	Дотоод албан томилолт	553,400.00	1,369,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	367,756,584.00	252,563,839.00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	366,630,484.00	251,992,039.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,600.00	73,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	273,500.00	215,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,853,182.07</b>	<b>99,588,758.78</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	462,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,853,182.07	99,126,758.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,623,732.00</b>	<b>349,400,794.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,171,192.00</b>	<b>49,159,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,171,192.00	49,159,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>18,452,540.00</b>	<b>300,241,394.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,452,540.00	300,241,394.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-72,390,727.07</b>	<b>215,890,995.22</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>79,251,850.06</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	79,251,850.06	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-79,251,850.06</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-151,642,577.13</b>	<b>215,890,995.22</b>



### **2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

---

*Төгрөгөөр*



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,371,496,431.00</b>	<b>1,724,269,022.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,155,000.00</b>	<b>700,000.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,155,000.00	700,000.00	
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,155,000.00	700,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,155,000.00	700,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,370,341,431.00</b>	<b>1,723,569,022.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,188,200.00	71,960,007.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,275,000.00	64,120,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	913,200.00	7,840,007.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,334,922,300.00	1,644,352,800.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,334,922,300.00	1,644,352,800.00	
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	28,230,931.00	7,256,215.00	
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	28,230,931.00	7,256,215.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,269,157,154.00</b>	<b>1,690,740,822.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,269,157,154.00</b>	<b>1,690,740,822.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,200,957,015.00</b>	<b>1,283,493,910.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	700,362,900.00	706,437,005.00	
210101	Үндсэн цалин	552,714,740.00	510,954,324.35	
210102	Нэмэгдэл	115,007,016.00	170,020,832.13	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,641,144.00	25,461,848.52	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,574,000.00	94,241,500.00	
210201	Тэтгэврийн даатгал	66,687,200.00	66,183,400.00	
210202	Тэтгэмжийн даатгал	6,971,700.00	7,158,100.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,577,400.00	5,573,300.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,394,300.00	1,393,300.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	13,943,400.00	13,933,400.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,548,600.00	22,671,200.00	
210301	Гэрэл, цахилгаан	1,591,700.00	5,018,377.00	
210302	Түлш, халаалт	16,960,000.00	16,036,694.00	
210303	Цэвэр, бохир ус	996,900.00	1,616,129.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,750,200.00	15,581,700.00	
210401	Бичиг хэрэг	4,867,500.00	3,445,850.00	
210402	Тээвэр, шатахуун	14,161,700.00	9,441,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,800.00	575,550.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,945,200.00	2,119,200.00	
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	4,981,000.00	2,484,200.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,981,000.00	2,484,200.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,041,500.00	6,082,800.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,725,000.00	2,109,500.00	
210604	Урсгал засвар	6,316,500.00	3,973,300.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	553,400.00	1,369,300.00	
210702	Дотоод албан томилолт	553,400.00	1,369,300.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	345,353,415.00	433,966,205.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	344,227,315.00	433,394,405.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00	
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	250,000.00	



210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,600.00	73,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	273,500.00	215,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>792,000.00</b>	<b>660,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	792,000.00	660,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,200,139.00</b>	<b>407,246,912.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,171,192.00</b>	<b>49,159,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,171,192.00	49,159,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>26,028,947.00</b>	<b>358,087,512.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,028,947.00	358,087,512.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>102,339,277.00</b>	<b>33,528,200.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>102,339,277.00</b>	<b>33,528,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>102,339,277.00</b>	<b>33,528,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>102,339,277.00</b>	<b>33,528,200.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	102,339,277.00	33,528,200.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-102,339,277.00</b>	<b>-33,528,200.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,645,352,800.00	1,344,811,406.00	300,541,394.00	81.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,645,352,800.00	1,344,811,406.00	300,541,394.00	81.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,596,193,400.00	995,410,612.00	600,782,788.00	62.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	712,137,400.00	701,033,810.00	11,103,590.00	98.4
210101	Үндсэн цалин	591,196,500.00	505,551,129.35	85,645,370.65	85.5
210102	Нэмэгдэл	96,242,400.00	170,020,832.13	-73,778,432.13	176.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,698,500.00	25,461,848.52	-763,348.52	103.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,241,500.00	94,241,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	66,374,800.00	66,183,400.00	191,400.00	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,966,700.00	7,158,100.00	-191,400.00	102.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,573,300.00	5,573,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,393,300.00	1,393,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,933,400.00	13,933,400.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,671,200.00	22,671,200.00	0.00	100.0



210301	Гэрэл, цахилгаан	3,887,200.00	5,018,377.00	-1,131,177.00	129.1
210302	Түлш, халаалт	16,960,000.00	16,036,694.00	923,306.00	94.6
210303	Цэвэр, бохир ус	1,824,000.00	1,616,129.00	207,871.00	88.6
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,185,200.00	17,185,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	3,100,000.00	3,445,850.00	-345,850.00	111.2
210402	Тээвэр, шатахуун	9,441,100.00	9,441,100.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	921,400.00	575,550.00	345,850.00	62.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,722,700.00	3,722,700.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	2,484,200.00	2,484,200.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,484,200.00	2,484,200.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,917,500.00	13,917,500.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,944,200.00	9,944,200.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,973,300.00	3,973,300.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,369,300.00	1,369,300.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,369,300.00	1,369,300.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	731,527,100.00	141,847,902.00	589,679,198.00	19.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	730,952,500.00	141,276,102.00	589,676,398.00	19.3
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,300.00	73,300.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	35,800.00	33,000.00	2,800.00	92.2
210807	Газрын төлбөр	215,500.00	215,500.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	660,000.00	660,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	660,000.00	660,000.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	49,159,400.00	49,159,400.00	0.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	49,159,400.00	49,159,400.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,159,400.00	49,159,400.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,645,352,800.00	1,344,811,406.00	300,541,394.00	81.7
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,644,352,800.00	1,344,111,406.00	300,241,394.00	81.7
132001	Орон нутгийн төсвөөс	1,644,352,800.00	1,344,111,406.00	300,241,394.00	81.7
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	700,000.00	300,000.00	70.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	700,000.00	300,000.00	70.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	73.00	73.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	69.00	69.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100.0



## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

<i>Төгрөгөөр</i>		
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>79,216,222.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>79,216,222.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	21,370,104.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,370,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,370,104.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>57,846,118.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	57,846,118.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	79216222.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>79,216,222.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,256,215.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,840,007.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Байгаль орчин, аялал жуулчлалын газартай холбоотой шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, өр төлбөрийг барагдуулах, тээвэр шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын эрхэм зорилгыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн



тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 1,343.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 20.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Авлагын дансны эхний үлдэгдэл 10.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 60.5 сая төгрөг болж 50.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд авлага нэмэгдсэн шалтгаан нь нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 57.8 сая төгрөгийг авлагаар тусгасан, ажилчдаас авах үнэт цаасны тооцооны авлага барагдаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 143.3 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 353.4 сая төгрөг болж 210.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь аж ахуйн материал болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн болон өмнөх онд нөөцийн бараа дансанд бүртгэсэн 66.8 сая төгрөгийг бараа материалыг тайлант онд бусад хангамжийн материалын дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь тайлант онд 9.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, дахин үнэлж үнэ тогтоохоор данснаас хассан 114.9 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдаж, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 33.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, хандиваар авсан 5.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, дахин үнэ тогтоож орлого авсан, 57.5 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 795.7 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 792.6 сая төгрөг болж буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн тухайд нийт орлого өмнөх онд 1,371.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 1,724.3 сая төгрөг болж 352.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэл өмнөх онд 56.3 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 30.6 сая төгрөг болж 25.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь бараа үйлчилгээний бусад зардлын тооцооны өр төлбөрийг тодорхой хэмжээнд төлж бууруулсантай холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.



### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2021 оны төсвийн төслийг 2,109.0 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн саналаа аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн нэгтгүүлсэн бөгөөд төсвийг анх 1,400.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 1,400.9 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд тодотголоор 244.5 сая төгрөгийн төсвийг нэмж нийт 1,645.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс орон нутгийн төсвөөс 1,644.3 сая төгрөгийг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,644.4 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.7 сая төгрөг нийт 1,645.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Бараа үйлчилгээний зардалд 955.4 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 349.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн төсвийн хэмнэлт гарган ажиллаж орон нутгийн төсөвт 300.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 81.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.8 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас хүрэн баавгай арга хэмжээнд 26.0 сая төгрөгийг, Био 00-ийн санхүүжилтэд 38.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.2 сая төгрөг нийт 79.2 сая төгрөгийн орлогыг хуваарилсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт хураамжийн зардалд 21.8 сая төгрөгийг зарцуулж 57.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар асуудлыг онцолсон хэсэг байхгүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.
- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн БОАЖГ-ын Ойн албаны мэргэжилтэн Л.Батхүүг өндөр насны тэтгэвэрт гарахад нь 22.3 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох байсныг 25.9 төгрөгөөр тооцож нийт 3.6 төгрөгийг илүү олгосон байна.

Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Жолоочийн тооцоог сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтаар хөтлөөгүй хүчингүй болсон маягтаар хөтөлсөн байна. Жолоочийн тооцоог бодохдоо ядсан км-ийн заалт, явсан хүний гарын үсэг байхгүй бөгөөд зааврын дагуу хөтлөөгүй байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг 30.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хоолны зардалд нийт 6.5 сая төгрөгийг Танил жаргалан ХХК-д шилжүүлсэн байна. Үүнээс 5.8 төгрөгийг "Тэр бум мод" хөтөлбөртэй холбоотой уулзалт зөвлөгөөний хоолны зардалд, өмнөх оны хоолны зардлын өр төлбөрийн үлдэгдэлд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2021 онд нийт 2,468.0 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 672.7 сая төгрөгийн 25 мэдээл, орлогын 249.3 сая төгрөгийн 9 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 249.3 сая төгрөгийн 15 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 183.1 сая төгрөгийн 22 мэдээл нийт 1,824.3 сая төгрөгийн 71 мэдээллийг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 281.2 сая төгрөгийн 4 мэдээлэл, зарлагын 10.7 сая төгрөгийн 1 мэдээл нийт 291.9 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитаар нийт 2,116.2 сая төгрөгийн 76 зөрчил илэрсэн.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**



Тус байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээний хэрэгжилт баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 57.5 сая төгрөгийн 1 алдаа, 41.8 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс аудитын хугацаанд 57.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж 3.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 38.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,116.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

### Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 57.5 сая төгрөгийн залруулгыг хийсэн. Үүнд:

Үндсэн хөрөнгийг данснаас хасаж үнэ тогтоон орлого авахдаа үндсэн хөрөнгө данснаас хассан зардал гэж буруу данс сонгосон нь өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн тул аудитын хугацаанд залруулсан.

### Төлбөрийн акт:

Хөвсгөл аймгийн Байгал орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн Л.Батхүүг өндөр насны тэтгэвэрт гарахад нь 22.3 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох байсныг 25.9 төгрөгөөр тооцож нийт 3.6 төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.2. "Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Өглөгийн данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын дансанд Бараа үйлчилгээний зардлын 30.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж өглөгийг барагдуулах.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал



#### 2.1. Илрүүлэлт:

Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан зааврын хавсралттай нийцэхгүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх.

### 3. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### 3.1. Илрүүлэлт:

Жолоочийн тооцоог сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтаар хөтлөөгүй хүчингүй болсон маягтаар хөтөлсөн байна. Жолоочийн тооцоог бодохдоо ядсан км-ийн заалт, явсан хүний гарын үсэг байхгүй бөгөөд зааврын дагуу хөтлөөгүй байна.

#### 3.2. Өгсөн зөвлөмж:

Түлш шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж жолоочийн тооцооны хуудсыг маягтын дагуу хөтлөх илүү, дутууг нь тооцон баталгаажуулж байх.

### 4. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### 4.1. Илрүүлэлт:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хоолны зардалд нийт 6.5 сая төгрөгийг Танил жаргалан ХХК-д шилжүүлсэн байна. Үүнээс 5.8 төгрөгийг "Тэр бум мод" хөтөлбөртэй холбоотой уулзалт зөвлөгөөний хоолны зардалд, өмнөх оны хоолны зардлын өр төлбөрийн үлдэгдэлд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.5 дахь заалттай нийцэхгүй байна.

#### 4.2. Өгсөн зөвлөмж:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж уулзалт зөвлөгөөний хоолны зардлыг санхүүжүүлэхгүй байх.

### 5. **Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

#### 5.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 672.7 сая төгрөгийн 25 мэдээл, орлогын 249.3 сая төгрөгийн 9 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 249.3 сая төгрөгийн 15 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 183.1 сая төгрөгийн 22 мэдээл нийт 1,824.3 сая төгрөгийн 71 мэдээллийг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 281.2 сая төгрөгийн 4 мэдээлэл, зарлагын 10.7 сая төгрөгийн 1 мэдээл нийт 291.9 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитаар нийт 2,116.2 төгрөгийн 76 зөрчил илэрсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

#### 5.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	<b>БОАЖГ</b> <i>Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой</i>	6	99.3	1	57.5	1	3.6			4	38.2
2	<b>БОАЖГ</b> <i>Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой</i>	76	2,116.2							1	2,116.2
<b>Дүн</b>		82	2,215.5	1	57.5	1	3.6			5	2,154.4

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Төгрөгөөр
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>608,065,850.10</b>	<b>47,913,790.60</b>	<b>304,040,186.78</b>	<b>00.00</b>	960,019,827.48
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>608,065,850.10</b>	<b>47,913,790.60</b>	<b>304,040,186.78</b>	<b>00.00</b>	960,019,827.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>608,065,850.10</b>	<b>47,913,790.60</b>	<b>304,040,186.78</b>	<b>00.00</b>	960,019,827.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	215,890,995.22	00.00	215,890,995.22
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>608,065,850.10</b>	<b>47,913,790.60</b>	<b>519,931,182.00</b>	<b>00.00</b>	1,175,910,822.70